



**ХЭНГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 1107

Хэрлэн сум

**Техник төхөөрөмж хүлээн авах
комисс томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн наймдугаар хуралдааны 04 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үнэлгээний төхөөрөмж суурилуулсан 9 байгууллагын албан хаагчдын үйл ажиллагааг хянахад зориулагдсан техник төхөөрөмж хүлээн авах комиссыг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	С.Лхагвацэрэн	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Т.Баяртуяа	Аймгийн Засаг даргын Тамгын газрын нярав
Гишүүд:	Д.Зоригтбаясгалан	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
	Ш.Эрдэнэжаргал	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

2. Ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагын дагуу хүлээн авахыг Комиссын дарга (С.Лхагвацэрэн)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР